



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВ



Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, ...хууль зүйн туслалцаа авах” эрхийг хангах ажлын хүрээнд, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн холбогдогч, зарим төрлийн гэмт хэргийн хохирогч, эрх нь зөрчигдсөн хүүхэд, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой иргэний хэрэг, маргаан болон газар эзэмших эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Тус хөтөлбөрт 7 зорилтыг дэвшүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн сургууль, Монголын өмгөөлөгчдийн холбоог идэвхтэй оролцуулах, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, санхүүгийн эх үүсвэрийг хүртээмжтэй, үр ашигтайгаар хуваарилах зарчмыг баримтлан ажилласан.

Үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор 2008 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийг хэрэгжүүлж аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрх зүйн туслалцааны төв”-ийг бүх аймаг, дүүрэг болон хүн амын нягтаршил ихтэй зарим суманд байгуулан өнөөгийн Хууль зүйн туслалцааны төвийн үндэс суурийг тавьсан.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазад түшиглэн төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын эрх зүйн орчныг бүрдүүлж Монгол Улсын Их Хурлаар 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан.ы

Тухайн хуулийн хүрээнд зөвхөн төлбөрийн чадваргүй эрүүгийн хэргийн яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байсан бол Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хаврын чуулганаар “Хууль зүйн туслалцааны тухай хууль”-ийг эцэслэн баталснаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааг дан ганц эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлахгүйгээр зарим төрлийн гэмт хэргийн хохирогч, эрх нь зөрчигдсөн болон гэрч хүүхэд, иргэн болон захиргааны зарим төрлийн хэрэг, маргааны төлбөрийн чадваргүй оролцогч, нэхэмжлэгчид үзүүлэхээр хуульчилж, хамрах хүрээг өргөжүүлээд байна.

Тус төв нь улсын хэмжээнд ажлын алба болон 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, хүн ам ихээр төвлөрсөн 2 сумыг хамруулан нийт 31 салбарын 72 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа ба төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн мэдээлэл хийх, сургалт сурталчилгаа явуулах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.